



# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Мониторингийн тайлан

2018

ИРИМ  
СУДАЛГААНЫ САН

## IRIM судалгааны хүрээлэн

---



1503 тоот, Pro ONE барилга, Ногоон нуурын гудамж  
11-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот



46A/265 Улаанбаатар, Монгол



[www.irim.mn](http://www.irim.mn)



IRIMongolia



+976-7011-7101



[contact@irim.mn](mailto:contact@irim.mn)

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

---

“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал 2018: Мониторингийн тайлан”-г IRIM Судалгааны хүрээлэн өөрсдийн санаачилгаар 5 дахь жилдээ хийж гүйцэтгэв.

Мониторингийн багийн ахлагч	Хүрэлчулууны Баярмаа <i>IRIM судалгааны хүрээлэнгийн Судалгааны менежер</i>
Судлаач:	Даринчулууны Нарантуяа <i>IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач</i>
Туслах судлаач:	Хүрэлбаатарын Баярцэцэг <i>IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач</i>
Монгол хувилбарыг хянасан	Лхагваноровын Цэлмэгсайхан <i>IRIM судалгааны хүрээлэнгийн ТУЗ-ын гишүүн</i>
Англи хувилбарыг хянасан	Иан Бернард Лийч <i>IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх</i>

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Өмнөх жилүүдийн тайланг үзэх холбоос: <http://irim.mn/web-monitoring>

**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

---

**АГУУЛГА**

<b>ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>3</b>
<b>УДИРТГАЛ.....</b>	<b>5</b>
<b>БҮЛЭГ 1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ.....</b>	<b>6</b>
<b>БҮЛЭГ 2. ГОЛ ҮР ДҮН .....</b>	<b>9</b>
2.1. ЦАХИМ ХУУДАСНЫ ХАНДАЛТ .....	9
2.2. ЕРӨНХИЙ ҮР ДҮН.....	10
<b>БҮЛЭГ 3. ИЛ ТОД БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ТУС БҮРЭЭР.....</b>	<b>13</b>
3.1. ЯАМДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ .....	14
3.2. ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ .....	15
3.3. ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ .....	17
3.4. АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ.....	18
3.5. НИЙСЛЭЛИЙН ЗАХИРГАА, ДҮҮРГҮҮДИЙН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ.....	20
3.6. ПАРЛАМЕНТИЙН ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ.....	21
<b>ХАВСРАЛТ. ЦАХИМ ХУУДСУУДЫН ЭРЭМБЭЛЭЛТ</b>	

## ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ

МИТББМАЭТХ	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
ШДТХ	Шилэн дансны тухай хууль
МХХТ	Мэдээлэл, харилцаа, холбооны технологи

### Монгол Улсын яам

БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
СЯ	Сангийн яам
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЗТХЯ	Зам, тээвэр хөгжлийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

### Хэрэгжүүлэгч агентлаг

АЕГ	Архивын ерөнхий газар
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БТСГ	Биеийн тамир спортын газар
ГЕГ	Гаалын ерөнхий газар
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газар
ГБХЗХГ	Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МЭҮГ	Мал эмнэлэгийн үржлийн газар
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
СУГ	Соёл урлагын газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХҮЕГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ЦУОШГ	Цаг уур орчны шинжилгээний газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭМНДЕГ	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар

### Тохируулагч агентлаг

ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөөх газар

### Парламентийн харьяа байгууллагууд

ТАЗ	Төрийн Албаны Зөвлөл
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
УИХ	Монгол Улсын Их Хурал
МБ	Монгол банк

### Улаанбаатар хотын засаг захиргаа

НЗДТГ	Улаанбаатар
УХЗА	Улаанбаатар хотын захирагчын алба
БРД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
НД	Налайх дүүрэг
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг

## УДИРТГАЛ

Төр засгийн мэдээлэл, үйлчилгээг иргэдэд илүү хялбар, хурдан шуурхай хүргэх суваг нь төрийн байгууллагын цахим хуудас юм. Ялангуяа хурдтай өөрчлөгдөн буй өнөөгийн ниймийн хэрэгцээ шаардлага, мэдээлэл харилцаа холбооны боломжууд, хүмүүсийн амьдарлын хэв маяг нь энэхүү сувгийг үр дүнтэй ашиглахыг улам зайлшгүй болгож байна. Түүнчлэн, НҮБ-ын ‘Цахим Засаглалын Судалгаа’-нд тодорхойлсноор иргэндээ ээлтэй төрийн байгууллага гэдэг нь өөрийн мэдээлэл, үйлчилгээг хүргэхдээ мэдээлэл, харилцаа, холбооны технологи (цаашид МХХТ гэх)-ийг идэвхтэй ашигладаг, улмаар уг сувгийг ашиглан төрийн үйл хэрэгт иргэнийхээ оролцоог дэмждэг байна гэжээ (UN, 2018).

Манай орны хувьд “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрийг 2004 онд боловсруулж, тус хөтөлбөрийн хүрээнд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийг 2011 онд, “Шилэн дансны тухай” хуулийг 2014 онд тус тус баталсан байдаг. Эдгээр баримт бичгүүд нь төр засгийн байгууллагын ил тод, хариуцлагатай, ёс зүйтэй байдлыг хангах; төрийн байгууллагын төсвийн үр ашигтай захиран зарцуулалт, хариуцан тайлагналт, олон нийтийн хяналтыг бий болгох; ингэснээр төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх эрх зүйн үндсийг тавьж өгсөн. Гэвч иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал нь дээрх хууль, журамтай нийцэл тааруу байгааг онцолж ирсэн.

Тиймээс Хараат Бус Судалгааны Хүрээлэн дээр дурдсан эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын мониторингийг 2011, 2014, 2015, 2016, 2017, 2018 онуудад тус тус хийж гүйцэтгээд байна. Үр дүнгээс харвал, төрийн байгууллагын цахим хуудаснууд тогтсон стандартгүй, мэдээллээ тогтмол шинэчлэдэггүй, иргэдэд хүрэх ёстой мэдээллийг цахим хуудастаа байршуулдаггүй зэрэг нийтлэг дутагдлууд байна. Тиймээс, жил болгон давталттай хийж буй энэхүү мониторингийн тайлан нь төрийн байгууллага бүрээр цахим хуудасны үр ашигтай байдал хэрхэн сайжирч эсвэл муудаж буйг бүртгэн гаргаж, эрэмбэ үүсгэн, тогтмол сайжуулах хөшүүрэг болж байгаагаараа үнэ цэнэтэй ажил болж буй юм.



## БҮЛЭГ 1. МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ

### Мониторингийн зорилго:

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” (МИТББМАЭТХ)-ийн дагуу төрийн захиргааны байгууллагын цахим хуудаст мониторинг хийж, холбогдох ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг үнэлэх, цаашдын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой.

Мониторингийн баг дараах зарчмуудыг баримталсан:

- Өмнөх жилүүдийн мониторингийн арга зүйн зарчмыг баримтлах. Энэ нь 2018 оны үр дүнг өмнөх онуудтай харьцуулагдахуйц байдлыг хадгална. Ингэхдээ, үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал тус бүрээр үнэлэх;
- Төрийн байгууллагын төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг “Шилэн дансны тухай хууль” (ШДТХ)-ийн заалтуудыг баримтлан үнэлэх;
- Төрийн байгууллагын цахим хуудсыг ил тод байдлаар нь эрэмбэлж, үзүүлэлт тус бүрээр жагсаах;
- Цахим хуудаст тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах.

### Мониторингийн хамрах хүрээ, цаг хугацаа:

Мониторингийн мэдээллийг 2018 оны 09 дүгээр сарын 10-аас 30-ны хооронд цуглуулсан. Энэ хугацаанд 81 төрийн байгууллагын албан ёсны цахим хуудас бүгд бүрэн ажиллагаатай байсан.

- Яам -13;
- Хэрэгжүүлэгч агентлаг – 17;
- Төхируулагч агентлаг – 10;
- Орон нутгийн захиргаа – 21;
- Нийслэл, дүүргийн захиргаа – 11; болон
- Улсын Их Хурал, түүний харъяа байгууллага – 9 тус тус хамрагдсан.

### Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд:


Мониторингийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа “хэмжигдэхүйц”, “хэрэгжихүйц”, “бодитой” байх зарчмыг баримталсан. Мэдээллийн агуулгын шинжилгээг хийх нийтлэг шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо: Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагын ил тод байдлын тодорхойлолтод ашигласан үндсэн гурван үзүүлэлт; НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг, Нийгмийн Комиссын ашигласан нэг үзүүлэлт болон цахим хуудасны чанарыг үнэлэхэд өргөн ашигладаг стандарт үзүүлэлтийг нэмж нийт таван үзүүлэлт бүхий дизайн боловсруулсан Мониторингийн арга зүйд ашиглагдсан үзүүлэлтүүд, ил тод



## “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ” МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

байдлыг илтгэхэд аль нь илүү ач холбогдолтой үзүүлэлт вэ гэсэн ялгаатай байдлаар тогтоосон. Эдгээр үзүүлэлтийн нийт үнэлгээний системд эзлэх ач холбогдлыг Дүрс 1-д харуулав.

Дүрс 1. Цахим хуудасны ил тод байдлын шалгуур



**Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance):** Төрөөс иргэдэд үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг хүртэх боломжтой байдал. Нарийвчилбал, тухайн цахим хуудас нь МИТББМАЭТХ болон ШДТХ-д цахим хуудаст тавигдсан байхаар заасан дөрвөн хүрээний дагуух 40 төрлийн мэдээллийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэхийг хэмжинэ.

**Мэдээллийн найдвартай байдал (Reliability):** Тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэхийг илэрхийлнэ (Alanezi, Kamil, & Basti, 2010). Мөн МИТББМАЭТХ, ШДТХ-иуд дахь дөрвөн хүрээний дагуух 40 төрлийн мэдээлэл хэр найдвартай байгааг хэмжинэ.

**Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness):** Цахим хуудаст цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэхийг хэмжинэ (Harris, 2010). Өөрөөр хэлбэл, төрөөс иргэдэд хүргэж буй мэдээлэл цагаа олсон, тогтмол давтамжтай шинэчлэгддэг, уг мэдээллийг хэрэглэгчид хүлээн авч ашиглах боломжтой эсэхийг хянах юм.

**Цахим хуудсуудын хүртээмжтэй байдал (Accessibility):** Цахим хуудас нь хэрэглэгчид төрийн байгууллагад шууд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломж олгосон, хоёр талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг хэмжинэ (Drew & Nyerges, 2004, p. 57). Ингэхдээ дээрх гурван шалгуур үзүүлэлтээс ялгаатай нь мэдээллийн агуулгад бус цахим хуудаст өөрт нь холбогдох хэмжүүрүүдийн дагуу шинжилгээ хийх юм.

**Хэрэглэхэд хялбар байдал (Usability):** Хэрэглэгчид тухайн цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байгаа эсэх. Үүнд цахим хуудсуудын туслах хэрэгслүүд, үзэмж, төрх, дизайн зэрэг багтана (Weakley, 2004). Аливаа цахим хуудас нь иргэдийн интернэт хэрэглэх чадварт нийцсэн, энгийн, ойлгомжтой байх нь хэрэглэхэд хялбар байдлыг илтгэх чухал үзүүлэлт болдог.

Дээрх үндсэн таван үзүүлэлтийн тусламжтайгаар, **мэдээллийн дөрвөн хүрээг** үнэлсэн. МИТББМАЭТХ, ШДТХ-д заасан мэдээллийн ил тод байдлыг хангах үндсэн **мэдээллийн дөрвөн хүрээ** болох:

1. “Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал”,
2. “Хүний нөөцийн бодлогын ил тод байдал”,
3. “Төсөв, санхүүгийн ил тод байдал”,
4. “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал”-ыг хэрхэн хангаж байгааг хэмжсэн.

Энэхүү үзүүлэлтийг үнэлэхдээ Монгол улсын стандарт MNS 6285:2011 болох “Төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлага”-ыг хэрхэн хангаж байгааг шалгасан.

**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

Онцлон тэмдэглэхэд, дээрх хуулиудад заасан мэдээллийн зарим хүрээ болох төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл нь тусдаа нэгдсэн цахим хуудаст байрладаг тул тус бүрийн тусгайлсан цахим хуудсанд хандалт хийн үнэлсэн.

**Шалгуур үзүүлэлтүүдийн ач холбогдлын харьцаа:**

1. “Мэдээллийн холбогдолтой байдал” нь мэдээллийн ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүдээс хамгийн өндөр буюу 30 хувийг эзэлж байгаа. Энэ нь цахим хуудсанд тавигдсан байх ёстой мэдээллийн бүх хүрээ ямар нэг байдлаар тавигдсан байгааг илтгэнэ. Тиймээс энэ нь ил тод байдлыг үнэлэх хамгийн чухал үзүүлэлт болох юм.
2. Харин тухайн мэдээллийн чанарыг “мэдээллийн найдвартай байдал” ба “мэдээллийн цаг үеийн байдлын” үзүүлэлтүүдээр үнэлэх ба нийт үнэлгээний системд тус бүр 20 хувь, нийлээд 40 хувь эзэлнэ.
3. Эцэст нь мэдээлэл хэрхэн хүрч байна вэ гэдгийг “мэдээллийн хүртээмжтэй байдал” ба “хэрэглэхэд хялбар байдал” гэсэн үзүүлэлтээр хэмжих ба нийт үнэлгээний системд тус бүр 15 хувь, нийт 30 хувийг эзэлж байна.

Тухайн үзүүлэлтийг хэдэн хувьтай биелүүлснээс хамаарч төрийн байгууллагын цахим хуудасны **ил тод байдлыг** “Хаалттай”-аас “Бүрэн ил тод” хүртэл **4 түвшингээр** үнэлсэн (Хүснэгт 1-г харуулсан). Мониторингоос гарч ирсэн үр дүнг 5 шалгуур үзүүлэлт тус бүрээр хэрхэн тайлбарлаж байгааг дараах хүснэгтээс харж болно.

*Хүснэгт 1. Тухайн үзүүлэлтийг хангаж буй түвшин*

Хувь	Холбогдолтой байдал	Найдвартай байдал	Цаг үеийн байдал	Хүртээмжтэй байдал	Хэрэглэхэд хялбар байдал	Ил тод байдлын түвшин
<b>81-100</b>	Бүрэн холбогдолтой	Мэдээлэл бүрэн найдвартай	Мэдээлэл тогтмол шинэчлэгддэг	Бүрэн хүртээмжтэй	Хэрэглэхэд маш хялбар	<b>Бүрэн ил тод</b>
<b>61-80</b>	Холбогдолтой	Найдвартай	Ихэнхи мэдээлэл шинэчлэгддэг	Хүртээмжтэй	Хэрэглэхэд боломжтой	<b>Ил тод</b>
<b>41-60</b>	Зарим талаар холбогдолтой	Зарим талаар найдвартай	Зарим мэдээлэл шинэчлэгддэг	Зарим талаар хүртээмжтэй	Хэрэглэхэд төвөгтэй	<b>Зарим талаар ил тод</b>
<b>0-40</b>	Мэдээлэл огт байхгүй эсвэл холбогдолгүй	Найдваргүй	Хоцрогдсон мэдээлэл	Хүртээмжгүй	Хэрэглэхэд маш төвөгтэй	<b>Хаалттай</b>

## БҮЛЭГ 2. ГОЛ ҮР ДҮН


Энэ бүлэгт төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдлын дундаж үзүүлэлтийг өмнөх онуудын үр дүнтэй харьцуулан танилцуулна. Мөн цахим хуудасны “Хандалт”, “Хамааралтай байдал”, “Найдвартай байдал”, “Цаг үеийн байдал”, “Хүртгэмжтэй байдал”, “Хэрэглэхэд хялбар байдал” гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр ялган харуулна.

### 2.1. ЦАХИМ ХУУДАСНЫ ХАНДАЛТ

**Төрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлэл авах хэрэгцээ их байна.** Мониторингийн эхэнд бид тухайн цахим хуудсанд хандалт хийх боломж, төвөг саадгүй нэвтрэх боломжийг үнэлдэг. Үнэлгээнд хамрагдсан 81 төрийн байгууллагын бүх цахим хуудас хандалт хийхэд нээгдэж байсан. Үүнээс 7 байгууллагын цахим хуудас хэд хэдэн хандалтын дараа нээгдсэн. Тухайн цахим хуудсанд хандсан нийт хэрэглэгчдийн тоог харах боломж нийт байгууллагуудын 41.5 хувьд байна. Үүнээс 2018 онд хамгийн их хандалттай байгаа төрийн байгууллага нь Монгол Улсын Их Хурал (11,194,929 хандалт), үүний дараа Авлигатай Тэмцэх Газар (10,689,258 хандалт) байв. Хандагсдын тоо жилд дунджаар 1,7 сая байгаа нь иргэд төрийн байгууллагаас мэдээ, мэдээллийг цахим хуудсаар дамжуулан авах хэрэгцээ их байгааг илтгэнэ.

**Цахим хуудсаар дамжуулан иргэдтэй харилцах, зарим үйлчилгээг хонговчлох санаачлага буурсан байна.** Иргэдийн санал, бодлыг сонсох, цахимаар үйлчилгээ үзүүлэх зэрэг нь төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа сайжруулах, иргэдэд түргэн, шуурхай үйлчлэх нэг боломж юм. Дүрс 2-д харуулсанчлан, цахим хуудсанд тавигдсан мэдээлэлд сэтгэгдэл үлдээх боломж (6 хувиар) болон хуудсаар дамжуулан өргөдөл гомдол гарах боломж (19 хувиар) 2017 онтой харьцуулахад буурсан байна. Энэ нь иргэд төрийн үйлчилгээг мэдээлэл, технологийн дэвшил ашиглан хурдан шуурхай авах; төрөөс нийтэлсэн мэдээ мэдээллийг нягтлах, санал хүсэлтээ илэрхийлэх боломжууд нь хумигдсаныг илтгэнэ.

Дүрс 2. Цахим хуудасны эргэх холбоо




## “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ” МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

### 2.2. ЕРӨНХИЙ ҮР ДҮН


Нийт 81 төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг ерөнхийлөн дүгнэвэл 2018 онд “зарим талаар ил тод” (52.8 хувийг хангасан) гэж үнэлэгдлээ. Энэ нь анх 2011 онд үнэлгээ хийж эхэлснээс хойш 35 хувиар сайжирсан үзүүлэлт юм. Гэхдээ, дүрс 3-т харуулсанчлан, ил тод байдлын үнэлгээ 2015 онд 52.1 хувь хангасан гэж мэдэгдэхүйц сайжралт үзүүлснээс хойш энэ түвшиндээ зогсонги явж ирснийг дурдах хэрэгтэй.

Дүрс 3. Төрийн бүх байгууллагын ил тод байдлын дундаж үнэлгээ, %



Дүрс 4-т харуулсанчлан, сүүлийн хоёр жилийн үзүүлэлтээр “бүрэн ил тод” гэж үнэлэгдсэн байгууллага байхгүй. 2018 оны мониторингоор, “ил тод” ангилалд 22 байгууллага (27 хувь), “зарим талаар ил тод” ангилалд хамгийн олон буюу нийт 46 байгууллага (57 хувь) байв. “Хаалттай” буюу хангалтгүй оноо авсан 13 байгууллага (16 хувь) байна.

Дүрс 4. Төрийн байгууллагын ил тод байдлын түвшин




Энэ оны үр дүнг өнгөрсөн онтой харьцуулахад “ил тод” ангилалд төдийлөн өөрчлөлт гараагүй бол “зарим талаар ил тод” ангилалаас “хаалттай” ангилалд шилжсэн байгууллагын тоо 11-ээр нэмэгджээ.

# “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ” МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

Үүнийг таван үзүүлэлт тус бүрээр нарийвчлан харвал дараах байдалтай байна.


Дүрс 5. Ил тод байдлыг хэмжих 5 шалгуур үзүүлэлтийн 2018 оны үр



Үзүүлэлтүүдийг нийт үнэлгээний системд эзлэх ач холбогдлоор нь хувааж өгсөн (Дүрс 5). Үзүүлэлт бүрийн дундаж үнэлгээг нарийвчлан харвал тавин хувийн гүйцэтгэлтэй байна. Эдгээр таван үзүүлэлтээс цахим хуудсыг ач холбогдлын зэрэгтэйгээ харьцуулахад ‘хэрэглэхэд хялбар байдал’ нь бусад үзүүлэлтээсээ арай өндөр байгаа нь төрийн байгууллагуудын цахим хуудасны дизайн, харьцангуй сайн байгааг харууллаа. Ялангуяа үсгийн фонт тохиромжтой, сайтын цэс ойлгомжтой, өнгөний зохицол сайн зэрэг үзүүлэлт 97 хувиас дээш үнэлгээ авч байна.

Жил ирэх тусам төрийн байгууллагуудын цахим хуудаснууд шинэчлэгдэж, илүү боловсронгуй болсон нь илт мэдэгдэж байгаа. Гэсэн хэдий ч байгууллагууд цахим хуудасны мэдээллийн чанарт анхаарахгүйн улмаас нийт үнэлгээний түвшин ахихгүй хэвээр байна (Дүрс 6).

Дүрс 6. Сангийн яамны цахим хуудасны хүний нөөцийн цэс, 2015 ба 2018 онд




Харин эсрэгээр ‘мэдээллийн цаг үеийн байдал’ үзүүлэлт нь харьцангуй муу үзүүлэлттэй байна. Шалтгаан нь тухайн мэдээллийг оруулсан хугацаа нь тодорхой бус, тендерт шалгарсан болон

## “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ” МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

шалгараагүй оролцогчдын үндэслэл, шалтгаан болон худалдан авах ажиллагаанд хийсэн хяналт, шалтгалт, аудитын дүн зэрэг мэдээллийг маш бага хэмжээнд байршуулжээ.

Мэдээллийн хамрах хүрээний дагуу ил тод байдлыг хэмжихэд дараах үр дүн гарч байна.

Дүрс 7. Мэдээллийн дөрвөн хүрээний дагуу ил тод байдлын үнэлгээ



МИТББМАЭТХ-д заасан мэдээллийн ил тод байдлыг хангах үндсэн дөрвөн хүрээгээр үнэлвэл 2018 оны гүйцэтгэл 54 хувьтай байна. 2017 онтой харьцуулахад худалдан авах ажиллагааны ил тод байдал нь 1,4 хувиар өсч, бусад нь буурсан үзүүлэлтийг харууллаа. Ялангуяа төсвийн ил тод байдал өнгөрсөн оныг хүртэл харьцангуй сайжирсан ч энэ онд 6,2 хувиар буурсан нь хамгийн муу үзүүлэлт болжээ. Үйл ажиллагааны ил тод байдал 3.9 хувь, хүний нөөцийн ил тод байдал 3.3 хувиар тус тус буурчээ.



### БҮЛЭГ 3. ИЛ ТОД БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ТУС БҮРЭЭР

Энэ хэсэгт төрийн байгууллагын ил тод байдлын үр дүнг байгууллага тус бүрээр харуулна. Ингэхдээ нийт төрийн байгууллагыг чиг үүргээр нь зургаан төрлийн ангилалд оруулсан. Үүнд: Яамд, Хэрэгжүүлэгч агентлагууд, Тохируулагч агентлагууд, Аймгуудын Засаг даргын тамгын газар, Дүүргүүдийн Засаг даргын тамгын газар болон Парламент, түүний харьяа байгууллагууд орно.


Эдгээрээс таван төрлийн байгууллага нь “зарим талаар ил тод” ангилалд байна (Хүснэгт 2).

*Хүснэгт 2. Яамдын ил тод байдлын нийлбэр оноо*

№	Яам	Нийлбэр оноо		Үзүүлэлт
		2017	2018	
1	Монгол Улсын яамд	51.5	59.3	Зарим талаар ил тод
2	Хэрэгжүүлэгч агентлагууд	54.1	59.7	Зарим талаар ил тод
3	Тохируулагч агентлагууд	51.8	48.8	Зарим талаар ил тод
4	Аймгуудын Засаг даргын тамгын газар	60.4	51.0	Зарим талаар ил тод
5	Дүүргүүдийн Засаг даргын тамгын газар	53.5	45.8	Зарим талаар ил тод
6	Парламентийн харьяа байгууллагууд	50.7	48.0	Зарим талаар ил тод
<b>Ерөнхий дундаж</b>		<b>54.6</b>	<b>52.9</b>	Зарим талаар ил тод

Үр дүнг өнгөрсөн онуудтай харьцуулвал, хэрэгжүүлэгч агентлагуудын ил тод байдал 4 гаруй хувиар сайжирч “ил тод” ангилалд багтжээ. Харин 2017 онд хамгийн өндөр үнэлгээтэй байсан аймаг, дүүргүүдийн цахим хуудас 2018 онд 10 орчим хувиар огцом буурсан нь сонирхол татаж буй нэг үр дүн юм (Дүрс 8).

*Дүрс 8. Төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал*



Дээрх үр дүнг байгууллагын төрөл тус бүрээр нарийвчлан дараах бүлгүүдэд харууллаа.



**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

**3.1.ЯАМДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

Үйл ажиллагаа явуулж буй 13 яамны албан ёсны цахим хуудасны үр дүнг дараах хүснэгтэд харуулав. Энэ онд 9 яам *ил тод* түвшинд хүрч үзүүлэлтээ ахиулж чаджээ. ХЗДХЯ-наас бусад нь эрэмбээ өсгөсөн байгаа нь сайн үзүүлэлт юм (Хүснэгт 3).

*Хүснэгт 3. Яамдын ил тод байдлын нийлбэр оноо*

№	Яам	Нийлбэр оноо		Эрэмбэ /Ранк/	
		2017	2018	2017	2018
1	Барилга хот байгуулалтын яам	51.3	73.2	54	4
2	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам	53.2	67.6	48	8
3	Зам тээвэр хөгжлийн яам	58.0	65.3	30	10
4	Эрчим хүчний яам	63.9	65.0	14	11
5	Эрүүл мэндийн яам	41.1	64.7	73	12
6	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам	59.3	64.0	28	15
7	Боловсрол соёл шинжлэх ухааны яам	53.3	62.1	46	21
8	Батлан хамгаалах яам	45.2	61.6	66	22
9	Сангийн яам	53.4	59.7	44	26
10	Гадаад харилцааны яам	57.2	56.3	31	33
11	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам	47.2	54.2	63	41
12	Байгаль орчин аялал жуулчлалын яам	43.2	47.5	70	58
13	Хууль зүй дотоод хэргийн яам	43.2	30.0	71	78
<b>Яамдын дундаж</b>		<b>51.5</b>	<b>59.3</b>		
<b>Ерөнхий дундаж</b>		<b>54.6</b>	<b>52.9</b>		

Мэдээллийн ил тод байдлыг нийтлэх ёстой мэдээллийн дөрвөн хүрээгээр авч үзвэл ЗТХЯ-ны цахим хуудас “Үйл ажиллагаа” болон “Хүний нөөц”-ийн ил тод байдлыг бүрэн хангасан байна. УУЯ-ны цахим хуудас “Төсвийн ил тод байдал”-ыг бүрэн хангасан. БХБЯ-ны цахим хуудас худалдан авах ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангасан байна (Хүснэгт 4).

*Хүснэгт 4. Яамдын цахим хуудасны ил тод байдал, дөрвөн хүрээгээр*

№	Яам	Байгууллагын үйл ажиллагаа	Хүний нөөц	Төсөв санхүү	Худалдан авах ажиллагаа	Дундаж үзүүлэлт
1	Зам тээвэр хөгжлийн яам	92.9	100.0	63.1	55.8	77.9
2	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам	78.6	74.3	70.2	63.9	71.7
3	Боловсрол соёл шинжлэх ухааны яам	71.4	74.3	78.8	60.7	71.3
4	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам	78.6	25.7	100.0	62.7	66.7
5	Сангийн яам	42.9	74.3	69.8	73.8	65.2
6	Батлан хамгаалах яам	92.9	25.7	67.0	72.0	64.4
7	Барилга хот байгуулалтын яам	64.3	17.1	96.8	78.8	64.2
8	Эрчим хүчний яам	85.7	25.7	93.2	46.0	62.7
9	Эрүүл мэндийн яам	78.6	45.7	57.4	64.1	61.5
10	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам	71.4	45.7	63.5	31.0	52.9
11	Гадаад харилцааны яам	57.1	8.6	73.4	57.5	49.2
12	Байгаль орчин аялал жуулчлалын яам	71.4	17.1	73.4	34.5	49.1
13	Хууль зүй дотоод хэргийн яам	71.4	25.7	25.7	0.0	30.7
<b>Ерөнхий дундаж</b>		<b>57.0</b>	<b>44.5</b>	<b>63.5</b>	<b>48.6</b>	<b>53.4</b>

**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

Гол анхаарал татах асуудлууд:

Яамдын үзүүлэлт 2017 онтой харьцуулахад энэ дөрвөн хүрээний мэдээллийг байршуулах байдал нэмэгдэж байгаа хэдий ч мэдээллийн найдвартай байдал, цаг үеийн байдал хангалтгүй байна.

- БОАЖЯ нь худалдан авах ажиллагааны урилга, журам, үр дүнг байршуулах байдал хангалтгүй. Мөн ХЗДХЯ нь таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бараа, , ажил, үйлчилгээний холбогдох баримт материалыг байршуулах байдал сул байна.
- Ихэнх яамдууд худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын болон бусад хяналт, шалгалтын үр дүнг байршуулаагүй.
- Мөн ихэнх яамдын цахим хуудсанд асуулт хариулт болон хэлэлцүүлгийн булан байхгүй байгаа нь иргэдтэй харилцан мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа сайжруулах боломжийг хязгаарлаж байна.

### 3.2. ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Үйл ажиллагаа явуулж буй 17 хэрэгжүүлэгч агентлагуудын албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн үр дүн дараах хүснэгтэд харуулав. Хэрэгжүүлэгч агентлагуудын тал хувь нь *ил тод* түвшинд байна. Ялангуяа эхний гурван байранд хэрэгжүүлэгч агентлагууд орж, ерөнхийдөө үзүүлэлт өссөн үр дүнг харууллаа (Хүснэгт 5).

*Хүснэгт 5. Хэрэгжүүлэгч агентлагуудын ил тод байдлын нийлбэр оноо*

№	Хэрэгжүүлэгч агентлаг	Нийлбэр оноо		Эрэмбэ /Ранк/	
		2017	2018	2017	2018
1	Татварын ерөнхий газар	55.9	77.6	34	1
2	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар	54.8	73.9	39	2
3	Гаалийн ерөнхий газар	54.8	73.6	38	3
4	Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	44.4	64.3	67	13
5	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	59.3	63.4	26	16
6	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	55.4	63.3	36	17
7	Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газар	42.4	62.4	72	18
8	Цаг уур орчны шинжилгээний газар	55.6	62.3	35	19
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	70.2	59.7	10	27
10	Гадаадын иргэн харьяатын газар	62.5	59.5	17	28
11	Иргэний нисэхийн ерөнхий газар	51.2	59.0	55	29
12	Ашигт малтмал, газрын тосны газар	62.2	56.8	18	32
13	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	59.3	55.6	25	36
14	Мал эмнэлгийн үржлийн газар	50.8	51.3	57	50
15	Биеийн тамир спортын газар	43.7	50.0	69	52
16	Соёл урлагийн газар	35.5	42.1	79	67
17	Архивын ерөнхий газар	61.3	39.5	21	70
	<b>Хэрэгжүүлэгч агентлагын дундаж</b>	<b>54.1</b>	<b>59.7</b>		
	<b>Ерөнхий дундаж</b>	<b>54.6</b>	<b>52.9</b>		

Мэдээллийн дөрвөн хүрээгээр ялгаж харвал, Гадаадын иргэн харьяатын газар, Цаг уур орчны шинжилгээ, Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн үржлийн газрын “Төсөв санхүүгийн ил тод байдал”-ын үнэлгээ бүрэн ил тод буюу 100 хувийн үнэлгээ авсан нь онцлууштай байна (Хүснэгт 6).

**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

*Хүснэгт 6. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ, дөрвөн хүрээгээр*

№	Хэрэгжүүлэгч агентлаг	Байгууллагын үйл ажиллагаа	Хүний нөөц	Төсөв санхүү	Худалдан авах ажиллагаа	Дундаж үзүүлэлт
1	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	85.7	34.2	67.9	69.1	64.2
2	Цаг уур орчны шинжилгээний газар	78.6	54.3	100.0	46.0	69.7
3	Гаалийн ерөнхий газар	64.3	91.4	100.0	69.1	81.2
4	Архивын ерөнхий газар	21.4	0.0	73.4	28.0	30.7
5	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	78.6	74.3	50.4	62.7	66.5
6	Татварын ерөнхий газар	57.1	17.1	96.1	96.8	66.8
7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	64.3	74.3	83.3	46.0	67.0
8	Гадаадын иргэн харьяатын газар	64.3	8.6	100.0	57.5	57.6
9	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	57.1	82.9	90.1	80.2	77.6
10	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар	85.7	91.4	96.1	77.0	87.6
11	Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	71.4	54.3	80.1	80.2	71.5
12	Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газар	78.6	82.9	83.3	34.5	69.8
13	Биеийн тамир спортын газар	50.0	8.6	83.3	34.5	44.1
14	Соёл урлагийн газар	71.4	8.6	63.5	11.5	38.7
15	Иргэний нисэхийн ерөнхий газар	78.6	77.1	83.3	44.2	70.8
16	Ашигт малтмал, газрын тосны газар	50.0	8.6	63.5	70.6	48.2
17	Мал эмнэлэгийн үржлийн газар	42.9	0.0	100.0	34.5	44.3
<b>Ерөнхий дундаж</b>		<b>64.7</b>	<b>45.2</b>	<b>83.2</b>	<b>55.4</b>	<b>62.1</b>

Гол анхаарал татах асуудлууд:

- Хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд “Хүний нөөц”-ийн ил тод байдлыг хангах байдал хангалтгүй. Ялангуяа албан хаагчдын ёс зүйн дүрэм, хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам болон хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг ихэнх агентлагууд байршуулаагүй.
- Төсвийн ил тод байдлыг хангах байдал хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд сайн байна. Гэвч зарим агентлагууд болох Архивын ерөнхий газар, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрууд төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хийсэн аудитын дүгнэлт болон дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг оруулаагүй.
- ГЗБГЗЗГ, БТСГ, СУГ, АЕГ зэрэг агентлагууд худалдан авах ажиллагаатай холбоотой урилга, мэдээлэл, аудитын дүгнэлт зэрэг мэдээллийг байршуулах байдал сул.
- Асуулт хариулт болон хэлэлцүүлгийн булан тухайн хэрэгжүүлэгч агентлагийн 64.7 хувьд нь байхгүй.
- Мөн тухайн хэрэгцээт мэдээллээ цахим хуудаснаасаа хэвлэх, хадгалах боломж ихэнх хуудсуудад бага байна.

**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

**3.3. ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

Тохируулагч 10 агентлагуудын албан ёсны цахим хуудаст мониторингийн үнэлгээ хийсэн. Тохируулагч агентлагуудын хувьд 2018 оны мэдээллийн ил тод байдал “зарим талаар ил тод” гэсэн ангилалд өмнөх онуудтай адил хэвээр байна (Хүснэгт 7).

*Хүснэгт 7. Тохируулагч агентлагуудын цахим хуудасны ил тод байдлын нийлбэр оноо*

№	Тохируулагч агентлаг	Нийлбэр оноо		Эрэмбэ /Ранк/	
		2017	2018	2017	2018
1	Цагдаагийн ерөнхий газар	74.3	69.9	4	6
2	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	49.4	69.9	59	7
3	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	59.5	64.0	22	14
4	Үндэсний хөгжлийн газар	52.2	60.2	51	25
5	Онцгой байдлын ерөнхий газар	61.6	55.9	19	35
6	Хил хамгаалах ерөнхий газар	63.7	54.8	15	40
7	Стандарт, хэмжил зүйн газар	58.4	53.0	29	45
8	Зэвсэгт хүчний жанжин штаб	26.5	27.9	80	79
9	Тагнуулын ерөнхий газар	22.6	18.9	81	80
10	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар	50.0	13.6	58	81
<b>Тохируулагч агентлагын дундаж</b>		<b>51.8</b>	<b>48.8</b>		
<b>Ерөнхий дундаж</b>		<b>54.6</b>	<b>52.9</b>		

Үүнийг мэдээллийн дөрвөн хүрээгээр харвал, хамгийн өндөр үзүүлэлттэй эхний гурван байгуулагад Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Үндэсний хөгжлийн газрын цахим хуудас жагсаж байна (Хүснэгт 8)

*Хүснэгт 8. Тохируулагч агентлагуудын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ, дөрвөн хүрээгээр*

№	Тохируулагч агентлаг	Байгууллагын үйл ажиллагаа	Хүний нөөц	Төсөв санхүү	Худалдан авах ажиллагаа	Дундаж үзүүлэлт
1	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	78.6	85.7	97.4	57.5	79.8
2	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	64.3	91.4	79.7	73.4	77.2
3	Үндэсний хөгжлийн газар	78.6	91.4	81.2	34.5	71.4
4	Цагдаагийн ерөнхий газар	57.1	25.7	97.4	67.3	61.9
5	Стандарт, хэмжил зүйн газар	42.9	82.9	81.2	23.0	57.5
6	Хил хамгаалах ерөнхий газар	50.0	60.0	52.2	67.3	57.4
7	Онцгой байдлын ерөнхий газар	64.3	17.1	90.9	46.0	54.6
8	Зэвсэгт хүчний жанжин штаб	28.6	8.6	32.9	23.0	23.3
9	Тагнуулын ерөнхий газар	64.3	0.0	0.0	0.0	16.1
10	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар	28.6	0.0	0.0	0.0	7.1
<b>Ерөнхий дундаж</b>		<b>55.7</b>	<b>46.3</b>	<b>61.3</b>	<b>39.2</b>	<b>50.6</b>

Гол анхаарах асуудлууд:

- ЗХЖШ, ТЕГ, ШӨХТГ зэрэг тохируулагч агентлагууд нийт байгууллагууд дундаас сүүлийн гурван байрт эрэмбэлэгдлээ. Ялангуяа сүүлийн хоёрт эрэмбэлэгдсэн

**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

байгууллагууд хүний нөөц, төсөв, санхүү болон худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг огт байршуулаагүй байна.

- ОБЕГ, ЗХЖШ, СХЗГ, ШӨХТГ зэрэг агентлагууд олон нийтэй харилцах мэргэжилтний мэдээлэл, иргэдийг хүлээн цагийн хуваарь зэрэг мэдээлэл байхгүй.
- Хууль, тогтоомжид заасан холбогдох төлбөр, хураамжийн хэмжээг ихэнх нь байршуулаагүй.
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын шалгалт, бусад хяналт шалгалтын дүнг нэг ч тохируулагч агентлаг байршуулаагүй.
- ТЕГ, ШӨХТГ зэрэг агентлагууд төсөв санхүү болон худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол хугацаанд шинэчилдэггүй.
- ЦЕГ-аас бусад агентлагуудын цахим хуудаснаас хүссэн мэдээллээ хэвлэх, хадгалах боломж бага байна.

**3.4. АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

Энэ онд аймаг, орон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудасны дундаж үнэлгээ өссөн боловч эрэмбийн хувьд байр ухарсан үзүүлэлттэй байна. Учир нь өнгөрсөн онуудад аймгуудын тал хувь нь эхний хорин байранд эрэмбэлэгдэж байсан бол энэ онд зөвхөн нэг л аймгийн цахим хуудас эхний хорьд, бусад нь хорьдугаар байрнаас хойш эрэмбэлэгджээ (Хүснэгт 9).

*Хүснэгт 9. Аймгуудын засаг даргын тамгын газрын цахим хуудасны ил тод байдлын нийлбэр оноо*

№	Аймгуудын засаг даргын тамгын газар	Нийлбэр оноо		Эрэмбэ /Ранк/	
		2017	2018	2017	2018
1	Дундговь аймаг	55.0	71.2	37	5
2	Увс аймаг	56.7	62.2	32	20
3	Орхон аймаг	74.6	61.4	3	23
4	Дархан-Уул аймаг	53.4	58.8	45	30
5	Баянхонгор аймаг	70.3	56.3	9	34
6	Говьсүмбэр аймаг	65.1	55.6	13	37
7	Хөвсгөл аймаг	76.7	55.4	1	38
8	Булган аймаг	61.3	54.8	20	39
9	Говь-Алтай аймаг	56.3	53.8	33	42
10	Хэнтий аймаг	72.5	53.7	7	43
11	Өмнөговь аймаг	54.2	53.7	41	44
12	Төв аймаг	48.9	51.8	60	47
13	Өвөрхангай аймаг	59.4	51.3	24	49
14	Дорноговь аймаг	65.4	48.2	12	55
15	Завхан аймаг	72.7	47.8	6	57
16	Сүхбаатар аймаг	68.2	46.1	11	60
17	Архангай аймаг	40.2	40.6	76	68
18	Дорнод аймаг	75.0	39.5	2	69
19	Сэлэнгэ аймаг	53.8	37.4	43	71
20	Ховд аймаг	36.0	36.0	78	73
21	Баян-Өлгий аймаг	53.2	35.7	47	74
<b>Аймгуудын засаг даргын тамгын газрын дундаж</b>		<b>54.1</b>	<b>51.0</b>		
<b>Ерөнхий дундаж</b>		<b>54.6</b>	<b>52.9</b>		

**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

Мэдээллийн үндсэн дөрвөн хүрээгээр хэрхэн үнэлэгдэж байгааг Хүснэгт 10-г үзүүлэв.

*Хүснэгт 10. Аймгуудын засаг даргын тамгын газрын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ, дөрвөн хүрээгээр*

№	Аймгуудын засаг даргын тамгын газар	Байгууллагын үйл ажиллагаа	Хүний нөөц	Төсөв санхүү	Худалдан авах ажиллагаа	Дундаж үзүүлэлт
1	Дундговь	64.3	100.0	72.9	77.0	78.5
2	Дархан-Уул	57.1	82.9	65.3	65.5	67.7
3	Орхон	57.1	82.9	63.9	65.5	67.3
4	Хэнтий	64.3	74.3	57.7	65.5	65.5
5	Дорноговь	57.1	91.4	63.9	42.5	63.7
6	Хөвсгөл	35.7	82.9	59.2	77.0	63.7
7	Говь-Алтай	50.0	91.4	63.9	44.2	62.4
8	Төв	28.6	91.4	66.8	55.8	60.6
9	Баянхонгор	50.0	65.8	57.7	67.3	60.2
10	Өмнөговь	42.9	74.3	81.9	32.7	58.0
11	Архангай	42.9	82.9	63.9	40.7	57.6
12	Булган	35.7	65.8	66.8	55.8	56.0
13	Увс	50.0	40.0	63.0	57.1	52.5
14	Говьсүмбэр	64.3	8.6	75.8	55.8	51.1
15	Өвөрхангай	64.3	17.1	65.8	54.0	50.3
16	Сэлэнгэ	50.0	100.0	38.2	11.5	49.9
17	Сүхбаатар	28.6	65.8	56.3	46.0	49.2
18	Баян-Өлгий	50.0	74.3	3.6	46.0	43.5
19	Завхан	64.3	8.6	47.3	44.2	41.1
20	Дорнод	7.1	0.0	47.3	55.8	27.5
21	Ховд	7.1	0.0	76.2	11.5	23.7
<b>Ерөнхий дундаж</b>		<b>46.3</b>	<b>61.9</b>	<b>59.9</b>	<b>51.0</b>	<b>54.8</b>

Гол анхаарах асуудлууд:

- Орон нутгийн захиргааны байгууллагын тал орчим нь үйл ажиллагааны стратеги, тэргүүлэх чиглэлээ байршуулаагүй.
- Өвөрхангай аймгаас бусад аймгийн захиргаа, шуудангийн хаяг нь тодорхойгүй.
- Хүний нөөцийн ил тод байдлыг Дундговь, Сэлэнгэ аймгууд бүрэн хангасан бол Дорнод, Ховд аймгууд огт хангаагүй байна.
- Ихэнх аймгийн захиргаа аудитын дүгнэлт болон дүгнэлтэнд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг байршуулаагүй.
- Мөн хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээг байршуулах байдал маш хангалтгүй байна.
- Нийт орон нутгийн захиргааны байгууллагуудын 90 орчим хувь нь холбогдох байгууллагын холбоос линк, түгээмэл асуултын хариулт зэрэг мэдээлэл байхгүй.



**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

**3.5. НИЙСЛЭЛИЙН ЗАХИРГАА, ДҮҮРГҮҮДИЙН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

Нийт идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй 11 дүүргийн албан ёсны цахим хуудаст мониторингийн үнэлгээ хийсэн. Нийслэл, дүүргийн захиргааны байгууллагын ил тод байдлын үзүүлэлт өнгөрсөн жилээс 8 орчим хувиар буурчээ (Хүснэгт 11).

*Хүснэгт 11. Дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдлын нийлбэр оноо*

№	Нийслэл, дүүргийн захиргаа	Нийлбэр оноо		Эрэмбэ /Ранк/	
		2017	2018	2017	2018
1	Сүхбаатар дүүрэг	71.2	60.8	8	24
2	Баянгол дүүрэг	73.2	57.0	5	31
3	Сонгинохайрхан дүүрэг	44.3	52.1	68	46
4	Налайх дүүрэг	40.5	50.0	75	53
5	Хан-Уул дүүрэг	62.8	48.1	16	56
6	Чингэлтэй дүүрэг	47.1	44.1	64	64
7	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	54.7	43.9	40	65
8	Улаанбаатар	40.6	42.7	74	66
9	Багахангай дүүрэг	53.1	36.5	49	72
10	Багануур дүүрэг	47.3	35.6	62	75
11	Баянзүрх дүүрэг	54.0	33.4	42	76
<b>Нийслэл, дүүргийн захиргааны дундаж</b>		<b>53.5</b>	<b>45.8</b>		
<b>Ерөнхий дундаж</b>		<b>54.6</b>	<b>52.9</b>		

Үүнийг мэдээллийн дөрвөн хүрээгээр нь авч үзвэл дараах үр дүнтэй байна (хүснэгт 12).

*Хүснэгт 12. Нийслэл, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ, дөрвөн хүрээгээр*

№	Нийслэл, дүүргийн захиргаа	Байгууллагын үйл ажиллагаа	Хүний нөөц	Төсөв санхүү	Худалдан авах ажиллагаа	Дундаж үзүүлэлт
1	Сонгинохайрхан дүүрэг	50.0	62.8	58.2	69.8	60.2
2	Сүхбаатар Дүүрэг	50.0	34.2	77.7	69.1	57.7
3	Баянгол	57.1	0.0	85.3	52.2	48.6
4	Налайх дүүрэг	64.3	8.6	44.7	73.8	47.8
5	Хан-Уул Дүүрэг	78.6	0.0	45.8	57.5	45.5
6	Багануур дүүрэг	57.1	68.6	8.6	42.5	44.2
7	Баянзүрх	71.4	62.8	36.8	0.0	42.8
8	Чингэлтэй дүүрэг	71.4	8.6	18.8	60.1	39.7
9	Улаанбаатар	35.7	34.2	43.6	42.5	39.0
10	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	57.1	0.0	44.3	32.7	33.5
11	Багахангай дүүрэг	35.7	0.0	39.7	32.7	27.0
<b>Ерөнхий дундаж</b>		<b>57.1</b>	<b>25.4</b>	<b>45.8</b>	<b>48.4</b>	<b>44.2</b>

Гол анхаарах асуудлууд:

- Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн захиргааны тал хувь нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө байршуулаагүй. Мөн ихэнх нь Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэл, жилийн санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг байршуулаагүй байна.



**“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

- БГД-ээс бусад нь хуульд заасан төлбөр хураамжийн хэмжээг цахим хуудастаа нийтлээгүй.
- Сул орон тооны зарын мэдээллийг шинэчилдэггүй.
- Дүүргүүд холбогдох байгууллагын холбоос болон тогтмол асуудаг асуултын хариулт цэсгүй байна.
- Бүх цахим хуудсанд тухайн хуудасны бүтцийг харуулсан цахим хуудасны замын зураг (sitemap) байхгүй.

**3.6. ПАРЛАМЕНТИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

Парламентийн харьяа дараах 9 байгууллагын цахим хуудаст хийсэн мониторингийн дүнг харуулав. Парламентийн харьяа байгууллагын дундаж үнэлгээ өмнөх оноос 2,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэхдээ энэ үр дүн нь ‘зарим талаар ил тод’ гэсэн ангилалд хэвээр байгаа юм (Хүснэгт 13).

*Хүснэгт 13. Парламентийн харьяа байгууллагын цахим хуудасны ил тод байдлын нийлбэр оноо*

№	Парламентийн харьяа байгууллага	Нийлбэр оноо		Эрэмбэ /Ранк/	
		2017	2018	2017	2018
1	Сонгуулийн ерөнхий хороо	59.3	66.3	27	9
2	Хүний эрхийн үндэсний комисс	52.1	51.5	52	48
3	Авлигатай тэмцэх газар	51.1	50.5	56	51
4	Монгол банк	36.3	49.6	77	54
5	Төрийн албаны зөвлөл	47.7	46.2	61	59
6	Санхүүгийн зохицуулах хороо	47.1	45.4	65	61
7	Үндэсний аудитын газар	52.3	44.7	50	62
8	Үндэсний статистикийн хороо	59.4	44.6	23	63
9	Монгол улсын их хурал	51.3	32.9	53	77
<b>Парламентийн харьяа байгууллагын дундаж</b>		<b>50.7</b>	<b>48.0</b>		
<b>Ерөнхий дундаж</b>		<b>54.6</b>	<b>52.9</b>		

Үүнийг мэдээллийн дөрвөн хүрээгээр нь авч үзвэл дараах үр дүнтэй байна (Хүснэгт 14).

*Хүснэгт 14. Парламентийн харьяа байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ, дөрвөн хүрээгээр*

№	Парламентийн харьяа байгууллага	Байгууллагын үйл ажиллагаа	Хүний нөөц	Төсөв санхүү	Худалдан авах ажиллагаа	Дундаж үзүүлэлт
1	Сонгуулийн ерөнхий хороо	42,9	17,1	63,5	88,5	53,0
2	Хүний эрхийн үндэсний комисс	78,6	91,4	43,6	32,7	61,6
3	Үндэсний аудитын газар	42,9	8,6	58,7	42,5	38,1
4	Үндэсний статистикийн хороо	50,0	17,1	40,4	42,5	37,5
5	Монгол банк	71,4	100,0	43,6	38,1	63,3
6	Монгол улсын их хурал	50,0	0,0	43,6	19,8	28,4
7	Төрийн албаны зөвлөл	50,0	25,7	61,9	11,5	37,3
8	Авлигатай тэмцэх газар	42,9	17,1	71,6	51,8	45,8
9	Санхүүгийн зохицуулах хороо	57,1	17,1	61,9	21,2	39,3
<b>Ерөнхий дундаж</b>		<b>54.0</b>	<b>32.7</b>	<b>54.3</b>	<b>38.7</b>	<b>44.9</b>

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”  
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

---

Гол анхаарах асуудлууд:

- Иргэдтэй харилцах мэдээлэл болох иргэдтэй уулзах цаг, онлайн туслах, шуудангийн хаяг зэрэг мэдээлэл 90 орчим хувьд нь байхгүй байна.
- Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг мониторинг хийх хугацаанд нэг ч байгууллага байршуулаагүй байв. Мөн ҮАГ-аас бусад байгууллага нь аудитын тайлан, дүгнэлтээ нийтлээгүй.
- Ихэнх байгууллагууд тендерийн урилгыг байршуулсан боловч холбогдох тендерийн баримт бичиг (ажлын даалгавар, тавигдах шаардлага гэх мэт), шалгаруулалтын журам, шалгараагүй үндэслэл, шалтгаан зэргийг байршуулаагүй.
- Гадаад хэлний сонголтыг солиход үр дүн нь бүх байгууллагаар жигд биш байв.


UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТ. ЦАХИМ ХУУДСУУДЫН ЭРЭМБЭЛЭЛТ

№	Төрийн байгууллагууд	Мэдээллийн хамааралтай байдал	Мэдээллийн найдвартай байдал	Мэдээллийн цаг үеийн байдал	Мэдээллийн хүргэмжтэй байдал	Хэрэглэхэд хялбар байдал	Нийлбэр хувь
1	Татварын ерөнхий газар	22.3	18	13.3	12	12	77.6
2	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар	25.4	18	12.5	3	15	73.9
3	Гаалийн ерөнхий газар	23.1	17	12.5	12	9	73.6
4	Барилга хот байгуулалтын яам	22.3	17	11.4	9	13.5	73.2
5	Дундговь аймаг	22.5	15.2	11	12	10.5	71.2
6	Цагдаагийн ерөнхий газар	21.5	16	11.4	9	12	69.9
7	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	22.3	16	10.6	9	12	69.9
8	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам	23.8	14	11.8	6	12	67.6
9	Сонгуулийн ерөнхий хороо	17.7	14	10.6	12	12	66.3
10	Зам тээвэр хөгжлийн яам	23.1	13	8.2	6	15	65.3
11	Эрчим хүчний яам	22.3	13	10.2	6	13.5	65
12	Эрүүл мэндийн яам	20	11	8.2	12	13.5	64.7
13	Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	22.3	16	11	6	9	64.3
14	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	24.6	16	11.4	3	9	64
15	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яам	21.5	12	9.4	9	12	64
16	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	19.2	10	8.6	15	10.5	63.4
17	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар	21.5	18	11.8	3	9	63.3
18	Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газар	20	12	9.4	9	12	62.4
19	Цаг уур орчны шинжилгээний газар	22.3	14	11	6	9	62.3
20	Увс аймаг	18.8	10.5	7.5	15	10.5	62.2
21	Боловсрол соёл шинжлэх ухааны яам	19.2	17	9.4	6	10.5	62.1
22	Баглан хамгаалах яам	23.8	13	8.2	3	13.5	61.6
23	Орхон аймаг	18.8	13.3	9.8	9	10.5	61.4
24	Сүхбаатар дүүрэг	20.3	14.3	9.8	9	7.5	60.8
25	Үндэсний хөгжлийн газар	20.8	12	9.4	9	9	60.2

26	Сангийн яам	16.9	13	11.8	6	12	59.7
27	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	18.5	13	10.2	9	9	59.7
28	Гадаадын иргэн харьяагын газар	20	15	11	6	7.5	59.5
29	Иргэний нисэхийн ерөнхий газар	21.5	13	9.4	6	9	59
30	Дархан-Уул аймаг	18.8	13.3	10.2	9	7.5	58.8
31	Баянгол дүүрэг	18	14.3	8.2	6	10.5	57
32	Ашигт малтмал, газрын тосны газар	16.9	11	9.4	9	10.5	56.8
33	Гадаад харилцааны яам	16.9	12	9.4	6	12	56.3
34	Баянхонгор аймаг	15.8	12.4	10.2	9	9	56.3
35	Онцгой байдлын ерөнхий газар	19.2	13	10.2	3	10.5	55.9
36	Төрийн өмчийн боллого зохицуулалтын газар	22.3	13	9.8	3	7.5	55.6
37	Говьсүмбэр аймаг	18	12.4	10.2	6	9	55.6
38	Хөвсгөл аймаг	16.5	13.3	10.6	6	9	55.4
39	Булган аймаг	14.3	12.4	10.2	9	9	54.8
40	Хил хамгаалах ерөнхий газар	16.2	12	8.6	9	9	54.8
41	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам	16.9	10	6.3	12	9	54.2
42	Говь-Алтай аймаг	17.3	11.4	8.6	6	10.5	53.8
43	Хэнтий аймаг	18	12.4	9.8	6	7.5	53.7
44	Өмнөговь аймаг	15.8	12.4	9	6	10.5	53.7
45	Стандарт, хэмжил зүйн газар	15.4	11	8.6	9	9	53
46	Сонгинохайрхан дүүрэг	19.5	14.3	6.3	6	6	52.1
47	Төв аймаг	15.8	12.4	10.2	3	10.5	51.8
48	Хүний эрхийн үндэсний комисс	17.7	8	6.3	12	7.5	51.5
49	Өвөрхангай аймаг	18.8	12.4	6.7	6	7.5	51.3
50	Мал эмнэлэгийн үржлийн газар	15.4	13	9.4	6	7.5	51.3
51	Авлигатай тэмцэх газар	17.7	10	7.8	9	6	50.5
52	Биеийн тамир спортын газар	15.4	11	8.6	6	9	50
53	Налайх дүүрэг	17.3	9.5	8.2	6	9	50
54	Монгол банк	17.7	8	7.5	9	7.5	49.6
55	Дорноговь аймаг	18	11.4	8.2	3	7.5	48.2

56	Хан-Уул дүүрэг	16.5	9.5	7.1	6	9	48.1
57	Завхан аймаг	15	8.6	6.3	6	12	47.8
58	Байгаль орчин аялал жуулчлалын яам	17.7	10	7.8	3	9	47.5
59	Төрийн албаны зөвлөл	13.8	7	5.9	9	10.5	46.2
60	Сүхбаатар аймаг	12	10.5	8.6	6	9	46.1
61	Санхүүгийн зохицуулах хороо	14.6	8	6.3	9	7.5	45.4
62	Үндэсний аудитын газар	13.8	10	5.9	9	6	44.7
63	Үндэсний статистикийн хороо	13.8	8	4.7	9	9	44.6
64	Чингэлтэй дүүрэг	15	7.6	3.5	6	12	44.1
65	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба	13.1	7	4.3	9	10.5	43.9
66	Улаанбаатар	13.8	8	5.9	6	9	42.7
67	Соёл урлагийн газар	14.6	7	5.5	3	12	42.1
68	Архангай аймаг	15.8	11.4	7.5	3	3	40.6
69	Дорнод аймаг	9	9.5	7.5	6	7.5	39.5
70	Архивын ерөнхий газар	10	10	7.5	3	9	39.5
71	Сэлэнгэ аймаг	13.5	5.7	4.7	6	7.5	37.4
72	Багахангай дүүрэг	9.8	6.7	5.1	6	9	36.5
73	Ховд аймаг	9	9.5	5.5	3	9	36
74	Баян-Өлгий аймаг	10.5	4.8	3.9	6	10.5	35.7
75	Багануур дүүрэг	12.8	4.8	3.1	6	9	35.6
76	Баянзүрх дүүрэг	14.3	4.8	2.4	6	6	33.4
77	Монгол улсын их хурал	10.8	5	5.1	6	6	32.9
78	Хууль зүй дотоод хэргийн яам	13.1	3	0.4	3	10.5	30
79	Эвсэгт хүчний жанжин штаб	8.5	5	3.9	3	7.5	27.9
80	Тагнуулын ерөнхий газар	6.9	0	0	3	9	18.9
81	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар	3.1	0	0	3	7.5	13.6



2018

“Төрийн байгууллагын цахим  
хуудасны ил тод байдал”  
тайлангийн хавсралт




ОУЛАН  
СУДАЛГААНЫ САН

Хараат Бус Судалгааны Хүрээлэн

12/3/2018

# Яамд

## 1. Байгаль орчин, аялал жуулчлалын яам



Цахим хуудсанд хандсан үйлчлүүлэгчийн тоог харах боломжгүй.

Мэдээлэлд сэтгэгдэл оруулах боломжгүй ч цахим хуудсаар дамжуулан өргөдөл гомдол гаргах боломжтой.

№	Сайтын хүртээмжтэй, хялбар байдал	2017	2018
1	Асуулт, хариултын булан	0	0
2	Хэлэлцүүлгийн булан	0	0
3	Холбоотой байгууллагын холбоос линк	1	1
4	Тогтмол асуудаг асуултуудын хариулт (FAQ)	0	0
5	Хэлний сонголт	1	0
6	Сайтын үсгийн фонтог тохиромжтой	1	1
7	Сайтын цэс ойлгомжтой	1	1
8	Сайтын өнгөний зохицол	1	1
9	Сайтын бүх мэдээлэл нь нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байна уу	0	1
10	Сайтад хайлтын цэс байна уу	1	1
11	Сайтад sitemap байна уу	1	0
12	Сайтаас хэвлэх боломж байна уу	0	0
13	Сайтаас файлыг хадгалах боломж байна уу	1	0
14	Сайтаас мэдээллийг бусдад илгээх боломж байна уу	0	0
<b>Нийт оноо</b>		<b>8</b>	<b>6</b>

№	Үйл ажиллагааны ил тод байдал	2017	2018
1	Эрхэм зорилго	1	1
2	Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт	1	1
3	Тэргүүлэх чиглэл	1	1
4	Олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр	0	1
5	Байгууллагын хаяг	1	1
6	Байгууллагатай холбоо барих утас	1	1
7	Факсын дугаар	1	0
8	Цахим шуудангийн хаяг	1	1
9	Иргэдийг хүлээн авч уулзах цагийн хувиар	1	1
10	Тухайн цахим хуудаснаас шууд холбогдох боломж	0	0
11	Шуудангийн хаяг	0	0
12	Төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт	0	1
13	Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, тогтоомж	1	0
14	Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам	1	1
<b>Нийт оноо</b>		<b>10</b>	<b>10</b>



“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ” ТАЙЛАНГИЙН  
ХАВСРАЛТ

№	Төсөв санхүүгийн ил тод байдал	2017	2018
1	Шилэн дансны тусгай цэс байгаа эсэх	1	1
2	Байгууллагын тухайн жилийн төсөв	1	1
3	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	1	1
4	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт	n/a	n/a
5	Урьд оны төсвийн гүйцэтгэл	0	0
6	Сар, улирлын гүйцэтгэл	1	1
7	Хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан	0	1
8	Төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	0	1
9	Аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	0	1
10	Төсвийн хэмнэлт хэтрэлт түүний шалтгааны тайлбар	0	1
11	Төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт	1	0
12	Хууль тогтоомжинд заасан төлбөр хураамжийн хэмжээ	0	0
<b>Нийт оноо</b>		<b>5</b>	<b>8</b>


№	Хүний нөөцийн ил тод байдал	2017	2018
1	Сул орон тооны зар	1	0
2	Албан хаагчийн ёс зүйн дүрэм	1	1
3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам	0	0
4	Хүний нөөцийн у ирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл	0	0
5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл	0	1
<b>Нийт оноо</b>		<b>2</b>	<b>2</b>

№	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	2017	2018
1	Тендерийн урилга	1	0
2	Тендерийн баримт бичиг	1	0
3	Тендер шалгаруулалт явуулах журам	0	0
4	Тендерт оролцохыг сонирхогчид тавигдах шалгуур үзүүлэлт	0	0
5	Тендерийн шалгаруулалтын талаарх м дээлэл, шалгарсан болон шалгараагүй үндэслэл	0	0
6	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан /5 сая.төг-с дээш/	0	1
7	Цалингийн зардлаас бусад 5 сая.төг-с дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга	0	0
8	ХА -нд хийсэн аудитын дүгнэлт, бусад хяналт, шалгалтын дүн	0	1
9	Мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр/бонд, зээл, өрийн бичиг гэх мэт/	0	1
<b>Нийт оноо</b>		<b>2</b>	<b>3</b>

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# Яамд

## 2. Гадаад харилцааны яам



Цахим хуудсанд хандсан үйлчлүүлэгчийн тоог харах боломжгүй.

Мэдээлэлд сэтгэгдэл оруулах болон цахим хуудсаар дамжуулан өргөдөл гомдол гаргах боломжгүй.

№	Сайтын хүртээмжтэй, хялбар байдал	2017	2018
1	Асуулт, хариултын булан	1	0
